# III БҮЛЭГ. ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ, ТАВИГДАХ ШААРДЛАГА

Санхүүжилтийн эх үүсвэр: Урсгал төсөв

Зориулалт: Баянхонгор аймгийн Татварын газрын байранд харуул хамгаалалтын үйлчилгээ үзүүлэх

Хэрэгжүүлэх хугацаа: 2024-2025 он

| № | Техникийн тодорхойлолт | Тавигдах шаардлага |
|---|---|---|
| 1 | Баянхонгор аймгийн Татварын хэлтсийн 1950 мкв талбай бүхий албан конторын барилга, автогражийн байр, гадна талбай, хашаанд 24 цагийн харуул хамгаалалтын үйлчилгээ үзүүлэх | Харуул хамгаалалтын үйлчилгээ, харуул хамгаалалтын үйлчилгээний хамрах хүрээ, чиг үүрэг:<br>1. Харуул хамгаалатын компани нь Баянхонгор аймгийн Баянхонгор сумын 7 дугаар багт байрлах Татварын газрын зоорийн болон авто граж бүхий 3 давхар 1950 мкв талбайтай объект, нийтийн эдэлбэрээс бусад манай байгууллагын гадна талбай, хашаа, өмч, хөрөнгөд 24 цагийн харуул хамгаалалтын үйлчилгээ үзүүлнэ.<br>2. Харуул хамгаалалтын компанийн харуул хамгаалалтын ажилтан нь “Үндэсний ажил мэргэжил , албан тушаалын жагсаалт, ангилал, тодорхойлолт батлах тухай “ 2010 оны 16 дугаар тушаалаар батлагдсан жагсаалт дахь 5414 кодтой “Хамгаалалтын албаны ажилтан”-ы тодорхойлолт, гүйцэтгэх чиг үүрэгт дурьдсан болон доорхи үйлчилгээг үзүүлж ажиллана.Үүнд:<br>2.1 Хамгаалах объектын өмч хөрөнгийг хулгайлах, хорлон сүйтгэх явдлаас хамгаалж, байгууллагад орох гарах хэсгийг хяналтандаа байлгаж, байгууллагын гадна, дотно аюулгүй байдлын талаарх нийтэд хамаарах дүрэм журмын хэрэгжилтийг хангуулах;<br>2.2 Хамгаалах объектод завшөөрөлгүй нэвтрэн орохоос урьдчилан сэргийлэх зорилгоор, цонх хаалгыг шалгаж, эргэж, тойрч байх;<br>2.3 Хамгаалах объектод нэвтрэх дотоод ажилтаны болон гадны хүний бичиг баримтыг шалгах, гарч , орж ирж байгаа хүмүүст хяналт тавих;<br>2.4 Дэг журмыг сахиулах, гадна дотны аливаа эрсдэлт үйлдлээс байгууллагын эд хөрөнгийг хамгаалах, дүрэм журмын хэрэгжилтийг хангуулахын тулд гадны зочид, иргэдэд шаардлага тавих;<br>2.5 Хамгаалах объектод үүсэх гал түймрийн болон ус, дулаан алдах гэх мэт аюул гарвал цаг алдалгүй Цагдаа, Онцгой байдал болон холбогдох бусад байгууллагуудад мэдэгдэх;<br>3. Монгол улсын Төрийн болон албаны нууцын тухай хууль, Байгууллагын нууцын тухай хууль, Хувь хүний нууцын тухай хуулийг мөрдөж ажиллана. |
| 2 | Нэмэлт ажил | 1. Шаардлагтай тохиолдолд байгууллагын дотоод үйл ажиллагаанд оролцох /тавилга эд хогшил зөөх, ачих буулгах ажил, лоц ломбо шалгах/, олон нийтийн хамарсан ажлуудад оролцох.<br>2. Гадна дотны цэвэрлэгээ тохижилтыг хариуцах /цас орсон үед байгууллагын үүд болон хариуцсан хэсгийн цас болон хог хаягдлыг зайлуулах, цэвэрлэгээ хийх, засаж сайжруулах/ автомашины зогсоолд байгаа авто тээврийн хэрэгслийн бүрэн бүтэн байдал, авто зогсоолын цэвэрлэгээг хариуцах |